



ДУНДГОВЬ АЙМАГ  
АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 11 өдөр

Дугаар А/90

Тавин

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх  
дархлаажуулалтын ажлыг зохион  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12 дахь заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6 дахь заалтууд, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны 10 сарын 02-ны өдрийн А/251 дугаар тушаал, Аймгийн Засаг даргын 2023 оны 10 сарын 10-ны өдрийн А/588 дугаар захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай

Ажлын хэсгийн ахлагч: А.Цолмонбаатар (Мал эмнэлгийн тасгийн  
малын эмч, тархвар зүйч)

Гишүүд: Ж.Батжаргал (1 дүгээр Багийн Засаг дарга)  
Ю.Туяамаа (2 дугаар Багийн Засаг дарга)  
Б.Төмөрчөдөр (3 дугаар багийн Засаг дарга)  
Э.Сэржмядаг (4 дүгээр Багийн Засаг дарга)  
Ё.Адилбиш (5 дугаар Багийн Засаг дарга)  
Б.Нацагдорж (ЦОАМАА ТЕРАПИЙ ХХК)  
Ц.Бат (Бага-Адаацаг ХХК)  
Ц.Зана (Жас Их Хонгор ХХК)

2. Малчид, мал бүхий иргэдэд мэдээлэл хүргэн, бэлэн байдлыг хангуулж Шүлхий өвчний дархлаажуулалтад бүх үхрийг бүрэн хамруулахыг Багийн засаг дарга нар, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн захирал нарт даалгасугай.

3. Дархлаажуулалтыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж шуурхай, үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн малын эмч, тархвар зүйч (А.Цолмонбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.УРАНЧИМЭГ